

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД 2025 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 10

Мандалговь хот

Д/Д	Гэрээнд заасан үүрэг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /хүрээгүй бол тайлбар/	Хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.</b>							
3.1.1	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах	Угийн бичиг хөтлөлтийн сургалт явуулж, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулах, Угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлнэ	Угийн бичиг хөтлөлтийн хувь	35	40	Аймгийн хэмжээнд 15 сумын Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар арга хэмжээг зохион байгуулснаар угийн бичиг хөтлөх иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлж, олон нийтэд сурталчлан таниулах зорилготой зохион байгуулан ажиллаж байна 15 сумын хэмжээнд шинээр угийн бичиг хөтөлсөн 335 өрх, 61 сургалт арга хэмжээнд 3596 иргэдийг хамруулсан байна. Зөвлөгөө мэдээллийг 65 зөвлөгөөнд 2074 гарын авлага, брошур тарааж, ажилласан байна. Угийн бичиг хөтлөлтийн хувь 51.4 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
3.1.2.1	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааны ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж ажиллах	Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөөг батлах /тийм-1 үгүй-0/	-	1	2025 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр орон нутагт хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох суурь судалгааны зардал болох 20,0 сая төгрөгийг төсөвт суулгуулсан. ГАЛТ ШУВУУ ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 9 сард байгуулан судалгааны ажил хийгдэж байна. Судалгааны ажлын гүйцэтгэл 30%-тай байна. Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга, Аудитын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, төрийн бус байгууллагын төлөөлөлүүдтэй уулзалт ярилцлага хийгдсэн. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох	0

						суурь судалгааны төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан	
			Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь	53	49	Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 158 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс гэмт хэргийн улмаас 49 мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр бүлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр 4 нэгжээр буурсан байна. Хүүхэд гэр бүл хөгжил, хамгааллын газарт 108 утсанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 41 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн Үүнээс үл хайхрах 14 сэтгэл санааны хүчирхийлэл 12 бие мах бодийн хүчирхийлэл 15, 4 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 3 гомдол мэдээллийг зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр хааж, 6 гомдолд зөрчлийн тухай хуулийн 5.2 буюу танхайрах зөрчлийн хэрэг нээж, 1 гомдол мэдээллийг хуурамч дуудлага мэдээлэл өгөх гэсэн үндэслэлээр хааж, шийдвэрлэсэн байна.	
3.1.2.2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн зэрэг арга зүйг түгээх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	8	10	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн зэрэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх аян, нөлөөллийн 10 ажлыг 15 сумын хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Үүнд Дэлхийн гэр бүлийн өдөрт зориулан Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, хамт олны дунд зэрэг харилцааг нэмэгдүүлэхэд зорилгын хүрээнд 1 сарын аянг “МИНИЙ ГЭР БҮЛ-МИНИЙ ТОЛЬ” аяныг 2070 хүүхэд, гэр бүл, иргэдийг хамруулан зохион байгуулсан. Энэхүү аяны хүрээнд гэр бүлийн модуль сургалтууд, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, Хүүхдийн ерөө байгуулах, хүүхэд хамгаалалын жишиг бодлого сэдвүүдээр мэдээллийг аймаг, сумдын төрийн байгууллагуудад хүргэж, ажилласан. Мөн Дэлхийн шилдэг кино арга хэмжээний хүрээнд гэр бүлийн сэдэвтэй киног үнэ төлбөргүй	50

				<p>оролцогчдод үзүүлэн киноны төгсгөлд кино хэлэлцүүлэг зохион байгуулсан. Сумдад хөтөлбөр боловсруулан “Хосын болзоо”, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд буухиа тэмцээн, гар зураг, эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулан ажилласан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйг түгээх сургалт, 5 нөлөөлийн ажлыг 8226 хүүхэд, иргэдэд түгээн дэлгэрүүлсэн</p>
		<p>Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь</p>		<p>Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууруулах зорилгоор гэр бүлийн хөгжлийн үйлчилгээнд 192, гэр бүлийн хамгааллын үйлчилгээнд 338, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 5833 хүн хамрагдсан, Давхардсан тоогоор нийт 8226 хүүхэд, насанд хүрэгч хамрагдсан байна. Тайлант хугацаанд 23 төрлийн сургалт, аян, нөлөөллийн үйл ажиллгааг, 12 төрийн болон төрийн бус байгууллагтай хамтран зохион байгуулсан.</p>

		Гэр бүлд чиглэсэн сэтгэл зүйн тусламж үзүүлэх үйлчилгээг "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан хэрэгжүүлж, зорилтот гэр бүлийн гишүүдэд амьдрах ухааны сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авсан иргэд, гэр бүлийн тоо	110	150	Байгууллагын нөөц боломжоо ашиглан "Гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө" өгөх танхим нээн гэр бүлүүдэд зөвлөгөө өгч ажиллалаа. "Монгол-өрх" сэтгэл зүйн хүрээлэнгийн зөвлөх сэтгэл зүйч С. Баасанбаттай хамтран, мэргэжлийн сэтгэл зүйн зөвлөгөөг үзүүллээ. Мөн гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хамгаалах байрны арга зүйч, сумдын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөөг 58 хүүхэд, 74 насанд хүрэгчид үзүүлсэн байна. Гэр бүлийн хөгжлийн үйлчилгээнд 192, гэр бүлийн хамгааллын үйлчилгээнд 338, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 5858 хүн хамрагдсан, Давхардсан тоогоор нийт 8251 хүүхэд, насанд хүрэгч хамрагдсан байна. Тайлант хугацаанд 23 төрлийн сургалт, аян, нөлөөллийн үйл ажиллгааг, 12 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Ингэснээр гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролыг олгоод байна.	100
3.1.2.3	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох						
3.1.2.4	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах	"Түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсвийг ИТХ-аар батлуулах"	Батлагдсан төсөв 100 хувь	100	100	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын дагуу Түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг 2026 оны төсөвт оруулах саналыг 2 удаа хүргүүлсэн. 2025 оны байдлаар хохирогч 9 иргэн, 25 хүүхэд нийт 35 иргэн, 74 хоног хамгааллын үйлчилгээ авсан байх бөгөөд нийт 9.1 сая төгрөг/ зарцуулсан байна. 2026 оны Түр хамгаалах байрны урсгал болон хүний нөөцийн зардлыг 2026 оны төсвийн төсөлд батлуулсан.	100
			Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95	100	100	"Түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсвийг Улсын төсвөөс 123.6 сая төгрөгийн санхүүжилтийг Иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлуулсан. Түр хамгаалах байрны урсгал	

			хувиас дээш биелэх			зардал 59.3 сая төгрөг, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал 7.5, хохирогчид үзүүлэх үйлчилгээний зардалд 9.1 төгрөгийг зарцуулан хэрэгжилтийг 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Түр хамгаалах байраар 35 хохирогчид 4 төрлийн үйлчилгээг үзүүлсэн. Хохирогчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр хохирогчид үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	
<b>3.1.3. Хүүхдийн эрхийн талаар</b>							
3.1.3.1	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийг оролцоог сайжруулах	Төлөвлөгөө баталсан эсэх /үгүй-0 тийм-1/	0	1	Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/847 дугаар захирамжаар Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, зөвлөлийн дүрмийг шинэчлэн, Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн саналыг салбар дундын байгууллагаас 2025 оны төлөвлөгөөнд 4 зорилт, 6 арга хэмжээг тусган Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93	95	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийг оролцоог хангахад чиглэсэн төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад улсын төсвөөс 610.000 төгрөг орон нутгийн төсвөөс 26.7 сая төгрөг зарцуулсан.	
3.1.3.2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх	Хүүхдийн оролцооны байгууллага, клуб, хүүхдээс гарсан санал санаачлага, үйл ажиллагааг дэмжиж ажиллах	Хөгжлийн үйчлилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	59	84	Хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын чанар хүртээмжийг сайжруулах, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, хүүхдээс гарсан санал санаачлагыг дэмжиж ажиллах чиглэлээр Ид шидийн орон Дундговь, хөгжлийн бэрхшээлтэй хүний төв, хүүхдийн оролцооны байгууллага, төрийн болон НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хүүхдийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Сумдын нийгмийн ажилтнууд байгууллагын дэргэд хаврын болон зуны	100

						хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөө гарган 2 удаагийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газарт хүүхдийн хөгжил оролцоог нэмэгдүүлэх, хөгжүүлэх, санал санаачлагыг дэмжих 11 төрлийн үйл ажиллагаанд 5205 хүүхэд, Ид шидийн орны хөгжлийн хөтөлбөрийн 23 дугуйланд нийт давхардсан тоогоор 9435 хүүхдийг хамруулсан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 511 дугаар захирамжаар Спорт заалыг үнэ төлбөргүй ашиглуулж, хүүхдийн хөгжлийг дэмжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх санал санаачлагыг дэмжих үйл ажиллагаанд 2245 хүүхэд хамрагдсан байна. Дээрх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь 89%-тай буюу өмнөх жилийн үзүүлэлтээс 29%-иар нэмэгдсэн байна. Хүүхдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хөгжүүлэх, санал санаачлагыг дэмжиж ажиллах дээрх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 393.1 сая төгрөгийг зарцуулсан байна.	
3.1.3.3	“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах	Шаардлагатай төсвийг батлуулах	Батлагдсан төсвийн хэмжээ	0	1	“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн үйл ажиллагаанд шаардагдах 100.0 сая төгрөгийн төсвийг ИТХ-аар хэлэлцүүлэн захиран зарцуулсан.	100
3.1.3.4	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангах	Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо	-	-	Хүүхдийн байгууллага үүсэж, хөгжсөний түүхт 100 жил, Дундговь аймгийн хүүхдийн байгууллагын 83 жилийн ойн үйл ажиллагааг зохион байгуулахад Гурвансайхан ХХК 200 хүүхдийн 10,000,000 төгрөгийн гарын бэлэг, Гео хөгжил ХХК 500,000 төгрөг, Говь принт 250 ширхэг 1,500,000 төгрөгийн урилганы хэвлэл, Тод өнгө ХХК 500,000 төгрөгийн бичиг хэргийн хэрэгсэл тус тус хандивласан байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 12.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	100

3.1.3.5	Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах	Хүүхдийн оролцооны байгууллагаас гаргасан санал санаачилгыг дэмжих	Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	19	35  Хүүхдийн оролцооны байгууллагаас гаргасан саналыг дэмжиж, ажиллах ажлын хүрээнд 42 оролцооны байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, байр танхимаар ханган хүүхдийн оролцоог нэмэгдүүлэн ажилласан. Аймгийн Хүүхдийн зөвлөлөөс хэрэгжүүлэн ажиллаж байгаа өсвөрийн парламент-2024 хөтөлбөрийн гишүүдээр төлөөлүүлж, хүүхэд, өсвөр насныханд сургуулийн орчин дахь эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдралын хэв маяг, дадал зуршилд уриалах, парламентийн боловсролын талаар мэдлэг олгох, оролцогчид хөтөлбөрөөс олж авсан мэдлэг мэдээллээ үе тэнгийнхэн, анги сургуулийнхан, багш нар, гэр бүлийнхэндээ түгээх, зэрэг нөлөөлөл үзүүлэх зорилгоор "Ирээдүйн иргэн" нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд оролцооны 1 байгууллагаас 2 санал ирснийг дэмжлэг үзүүлэн ахлах ангийн 400 хүүхдийг хамруулан ажилласан. Тус үйл ажиллагааг аймгийн хүүхдийн зөвлөлийн хүүхдүүдэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өрөө тасалгааны бэлэн байдлыг хангаж "ОХИД"-ын өрөөг гарган ажиллаж байна. Тус өрөөгөөр хүүхдүүд хичээлийн бус цагаар орой 19 цагаас өмнө нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хурал цуглаан зэргийг чөлөөт цагаар хийх боломжийг бүрдүүлэн ажилласан. Хүүхдээс гарсан санал санаачлагын дэмжих, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих эрхийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Ерөнхий болосролын сургуулиуд спорт залыг долоо хоногийн мягмар, пүрэв гарагт тогтмол үнэ төлбөргүй ашиглуулж байна. Орон нутгийн төсвөөс 4,000,000 сая төг зарцуулсан байна. Юнител группээс Шинжлэх ухаан, технологи,	100

						инженерчлэл, математикт суурилсан STEAM ХАБ хөтөлбөрийг 2022 оноос эхлэн 21 аймагт хэрэгжүүлж байгаа бөгөөд 2025 оны 11 сараас Дундговь аймагт хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Орон нутгийн төсвөөс 19,017,000 төгрөгийг зарцуулж хүүхэд, багачуудын суралцах орчиннөхжлийг бүрдүүлж, байр танхимаар хангаж өгсөн. Орон нутгийн төсвөөс 393.1 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.	
3.1.3.6	“Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Олон нийтийн байцаагчийн тоо	Тийм 1/Үгүй-0	0	1	Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар сум багт олон нийтийн байцаагч ажиллуулахаар баталсан. Олон нийтийн байцаагчийн бодлого чиг үүргийг иргэд олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор постер бэлтгэн олон нийтэд байршуулан мэдээлэл өгч ажилласан. Жилийн эцсийн байдлаар сум багт ажилллахаар бүртгүүлсэн олон нийтийн байцаагчаар ажиллах иргэн бүртгүүлээгүй байна.	50
		Илрүүлсэн хүүхдийн тоо	Үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	260	270	Сум багт ажиллахаар бүртгүүлсэн Олон нийтийн байцаагч байхгүй тул өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан 12 сум болон 8 багт гэрийн айлчлал хийж, шинээр томилогдон ажиллаж байгаа хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нарыг дайчлан эрсдэлт хүүхдийг илрүүлэн ажиллаж байна. Дээрх ажын хүрээнд 316 хүүхдийг илрүүлэн эрсдэлийн үнэлгээ хийж ажиллаж байна.  2025 оны байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд 25 дуудлага ирснээс 0-17 насны 34 хүүхдийн мэдээллийг хүлээн авч бүртгэн, эрх зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөөнд холбон зуучилж, хүүхдийн эрхийн зөвлөгөө мэдээллээр хангаж холбогдох хүсэлтийг шийдвэрлэж ажиллалаа. Эрсдлийн зэрэг дунд өндөртэй дуудлагыг харъяа сумын хамтарсан багт шилжүүлэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хяналт тавин ажиллаж байна. Кейс	

						шийдвэрлэлт 60%-тай байна. Тус үйл ажиллагааг зохион байгуулахад 5.588.980 төгрөг зарцууллаа.	
<b>3.1.4. Хүүхэд хамгааллын талаар</b>							
3.1.4.1	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх	"Хүүхэд хамгааллын бодлого"-ыг сурталчлан таниулах сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	12	13	"Миний гэр бүл-миний толь" аяны хүрээнд "Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл" "Хүүхдийн өрөө байгуулах, хүүхэд хамгаалалын жишиг бодлого сэдвүүдээр аймгийн төвд 28 байгууллагын 10 оролцогч, сумдын бүх төрийн байгууллага, сургууль, цэцэрлэг, ААНэгжийн төлөөлөлийн 1847 оролцогч хамрагдсан байх бөгөөд аймгийн хэмжээнд нийт 2070 оролцогчдыг хамруулан мэдээлэл хүргэж, ажиллалаа.	100
3.1.4.2	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	-	316	Хүүхдийн тусламжийн 108 утсанд жилийн эцсийн байдлаар 55 дуудлага ирснээс бие махбодийн хүчирхийллийн 15, сэтгэл санааны хүчирхийллийн 12, үл хайхрах хүчирхийллийн 16, бэлгийн хүчирхийллийн 6, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр 1, ахуйн осол гэмтэл 3, хууль эрх зүйн асуудал 2 дуудлагууд ирсэн байна. Нийт 84 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын шийдвэрлэлт 54% Гэмт хэрэг зөрчилд холбогдсон 2, хүмүүжлийн шинж чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 бэлгийн хүчирхийллийн хохирогч 5 хүүхдийн кейс дээр үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, өмгөөллийн үйлчилгээ сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилж, ажиллаа. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 293 хүүхэд байна.	100

	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө	Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв		-	Үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх үүднээс аймаг орон нутгийн төсвөөс 128.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Аймгийн хэмжээнд 17 урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд 14402 хүүхэд багачуудыг хамруулан нийт хүүхдийн 86 хувьд хүрч үйлчилсэн.	
3.1.4.3	зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх	баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж хэрэгжилтийг хангаж ажиллах	Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91	100	Дундговь аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/178 дугаар захирамжаар 13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталж, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн анхдугаар хуралдаанаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 2025 оны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай байна.	100

					<p>2025 оны жилийн эцсийн байдлаар Дундговь аймгийн хэмжээнд улс бүс сумдын 48 хурдан морины уралдаанд Дундговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын албан хаагчид болон 15 сумын хамтарсан багийн гишүүд хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа.</p> <p>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 151 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэл хүргүүлэн Хүүхэд хамгааллын тухай хууль, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах эрхийг хамгаалах журманд заасны дагуу бүрдүүлэх бичиг баримтын бүрдлийг үндэслэн давхардсан тоогоор <b>1346</b> хурдан морины уралдаанч хүүхдийг</p> <p><a href="https://intranet.gov.mn/main.php?p=Y2hbpGRyZW4">https://intranet.gov.mn/main.php?p=Y2hbpGRyZW4</a> программ болон цаасан суурьтайгаар бүртгэн 8-аас дээш насны хүүхдүүдийг, 100% гэнэтийн ослын даатгалд хамруулсан, стандартын шаардлагад нийцсэн хамгаалалтын хувцас хэрэглэлийг бүрэн өмссөн хүүхдүүдийг хурдан морины уралдаанд оролцуулахад хяналт тавьж ажиллалаа.</p>	
3.1.4.4	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах	Хяналт, шалгалтын тоо	11	11	100
			Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	100	100	

						хүүхдээ соль гэсэн шаардлага тавьсан боловч шаардлагыг хүлээж авахгүй хууль, захиргааны хэм хэмжээ зөрчсөн 3 уяачийг Зөрчлийн тухай хуулийн 6.20.11 дэх хэсэгт заасан үндэслэлээр 2 уяачийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 1 уяачид зөрчлийн хэрэг нээн шийдвэрлэж тус бүр 300.000 төгрөгийн торгууль ноогдуулж ажиллалаа.	
3.1.4.5	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Гамшиг, онцгой нөхцөлийн үед хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн өрхийн тоо, хүүхдийн тоо	100	100	Дундговь аймгийн Сайнцагаан суманд 2025 оны 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд "ТЭГШ ЭРХ – ТЭГШ ОРОЛЦОО" хүүхдийн 14 дүгээр чуулганыг зохион байгуулсан. Тус чуулганд 300 хүүхдийг хамруулсан. Тус сургалтын агуулгад гамшиг онцгой байдлын үед Анхны тусламж үзүүлэх модуль сургалтыг Монголын Хүүхдийн Зөвлөлийн Зөвлөх М.Бэхбат, Монголын Хүүхдийн Зөвлөл зохицуулагч А.Соёлоо, Монголын Хүүхдийн Зөвлөл төгсөгчдийн клуб Х.Мөнгөнцэцэг нар удирдан чуулганд оролцогч хүүхдүүдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Гамшиг онцгой байдлын үед дэх анхны тусламж, үзүүлэх модуль сургалтад 170 хүүхэд хамрагдсан. Мөн Онцгой байдлын газраас зохион байгуулсан гамшгийн сургалтад 12 албан хаагч буюу 37 өрхөд тус тус хүргэсэн байна. Дээрх арга хэмжээнд 25 том хүн, 170 хүүхэд хамрагдсан. Улсын төсвөөс 1.6 төгрөгийг зарцууллаа	100

		Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей,	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	1	1	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах ерөнхий шаардлага MNS6751:2019 стандартын хэрэгжилтийг хангуулах тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж, үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад тавьж, шийдвэрлүүлэх зорилгоор Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт байрлах 13 нийтийн эзэмшлийн хүүхдийн тоглоомын талбайд 2025 оны 4 дүгээр сарын 18-21-ний өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар санал, зөвлөмжийг Сайнцагаан сумын Засаг дарга болон "Мандлын гэгээ" хот тохижуулах газрын даргад хүргүүлж ажиллалаа.	60
3.1.4.6	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	45	70		60
3.1.4.7	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар дундын байгууллагуудтай хамтарсан хяналт	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	2	6	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд, шашны байгууллагууд Монгол улсын хууль тогтоомж, батлагдсан журмын дагуу зөвшөөрөл авч, хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор удирдамж гарган батлуулж 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 4 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Дундговь аймгийн Цагдаагийн газар, Сайнцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албатай хамтарсан хяналт шалгалтыг 2 хийд, 3 сүмийн үйл ажиллагаатай танилцаж, сүм хийдэд шавилан сууж байгаа болон өдрөөр үйлчилгээ авч байгаа хүүхдүүдийн эрх, хамгааллын хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 хийдэд шавилан суудаг 7 хүүхэд, сүмд өдрөөр	90
			Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	91	89		90

		шалгалтыг зохион байгуулах				үйлчилгээ авдаг 16 нийт 23 хүүхдийн судалгааг гаргаж тус тус ажилласан. Мөн хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлийг салбар дундын байгууллагуудаас авч нэгтгэн хамтарсан зөвлөмжийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдүүдэд өгч ажиллалаа. Хүүхдийн эрхийн зөрчил 3 хувиар буурсан байна	
<b>3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;</b>							
<b>3.2.1 Хөдөлмөрийн харилцааны талаар:</b>							
3.2.1.1	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах	ААНБ-д хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	67	75	6 сумын 102 ААНБ-ын 545 албан хаагчид, төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 47 ААНБ-ын 643 ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хуулийг таниулах сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.	100
3.2.1.2	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	Хөдөлмөрийн харилцааны сургалтад ААНБ, ажилтнуудыг хамруулах	Сургалтад хамрагдсан ААНБ-тоо	40	80	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн талаарх сургалтыг давхардсан тоогоор 149 аж ахуй нэгж байгууллагыг хамруулан зохион байгуулсан. Аж ахуйн нэгж байгууллагыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: Төрийн болон төсөвт байгууллага 51, аж ахуйн нэгж байгууллага 98 байна.	100
			Зохион байгуулсан сургалтын тоо	4	8	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 10 удаагийн сургалтыг Сайнцагаан, Баянжаргалан, Дэрэн, Өндөршил, Өлзийт, Цагаандэлгэр сумдын 102 Аж ахуйн нэгж байгууллагын 545 иргэнд, төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 47 ААНБ-ын 643 ажилтанд тус тус зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулсан	

3.2.1.3	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж, маргааны тоог бууруулах хөдөлмөрийн эрхийн маргааныг зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөрийн эрхийн маргааны тоо	1	1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын пэйж хуудсаар Хөдөлмөрийн харилцааны зөвлөхтэй хамтран Хөдөлмөрийн гэрээ, түүний төрлүүд, ажилтан ажлаас чөлөөлөх, малчин ажил олгогч болон туслах малчны хөдөлмөрийн харилцаа зэрэг 9 сэдвээр цуврал live хийж, сумдын Эрхийн маргаан зохицуулах 3 талт хорооны дарга, гишүүдэд линкийг хүргүүлэн оролцуулсан. Дээрх 9 цуврал лайв 1801 лайк, 977 коммент, 805 шэйртэй нийт 56024 хандалттай байна Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороонд 4 гомдол ирж, дээрх гомдол гаргасан иргэдийн 1 иргэн нь ажил олгогчтой эвлэрч, 1 иргэн нь гомдлоо буцааж, 2 иргэн нь ажил олгогчтойгоо тохиролцоогүй байна. Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороо өргөдлийн хариуг иргэдэд тэмдэглэл хэлбэрээр хүргүүлээ.	100
3.2.1.4	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачлагатай ажиллах	Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн хамтын хэлэлцээр байгуулах	Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо	1	1	Аймгийн хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг 2024-2026 оны хугацаанд хэрэгжихээр байгуулан, мэдээллийн сан үүсгээд байна.	100
<b>3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар</b>							
3.2.2.1	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;	Үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-н судалгааг гаргах	Судалгаа мэдээллийн тоо	1	-	Аймгийн хэмжээнд нийт бүртгэлтэй 1212 аж ахуй нэгж байгууллага байгаагаас үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй 665, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 291, бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 256 байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс 100 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн ахмад, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнесийн санаанд тулгуурлан дэмжлэгийг олгохоор иргэдэд нээлттэй сонгон	100

						шалгаруулалтыг зарлаад байна. Үр дүнд 5 ажлын байр бий болохоор хүлээгдэж байна.	
			Бодлогын баримт тусгасан бодлогын баримт бичгийн тоо	1	1	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт ажилгүй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн ур чадварын үнэлгээ хийх, хувийн төлөвлөгөө боловсруулах, бизнес эрхлэх ур чадварын сургалтад хамруулах, ажилгүй иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулж, байнгын болон түр ажлын байраар хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.	
3.2.2.2	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах	Хөдөлмөр эрхлэлтийн статистик тоо мэдээллийг сар бүр гаргаж иргэд олон нийтэд мэдээлэх	Судалгаа, Мэдээллийн тоо	11	11	Хөдөлмөрийн статистик тоон мэдээллийг сар бүр /11 удаа/ гарган аймгийн Статистикийн хэлтэс болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, <a href="http://shilen.gov.mn">shilen.gov.mn</a> , <a href="http://gov.mn">gov.mn</a> цахим хуудсаар сурталчилж байна.	100
3.2.2.3	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Зорилтод бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын дэлгэрэнгүй судалгаа гаргаж мэдээллийн сан үүсгэх, Иргэдийг хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, хэмжээнд хамруулах арга	Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь	0.5	1	Ажилгүйдлийн түвшин 2023 оны 4-р улирлын байдлаар 4,6 хувь, 2024 оны 4-р улирлын байдлаар 3,5 хувь буюу 1,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2025 оны 3-р улирлын байдлаар 1,5 хувь буюу өмнөх оноос 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	83,3
			Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь	0.5	1	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 26, ахмадын санхүүгийн дэмжлэгт 26, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн дэмжлэгт 18, жижиг зээлд 4 иргэн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих START-UP арга хэмжээнд 2 багийн 6 иргэн, Говийн бүсийн START-UP арга хэмжээнд 1 иргэн, тус тус хамрагдаж төслийн үр дүнд 81 иргэн байнгын ажлын байраар хангагдаж, ХЭДсангаас 910 сая төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2023 оны байдлаар 60,6 хувь, 2024 оны байдлаар 68,3	

						хувь буюу 7,7 хувиар өссөн бол 2025 оны 3-р улирлын байдлаар 58,9 хувь болж өмнөх оны мөн үеэс 6,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
			Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө (сая)	14,8	100	Иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, малчид, эмэгтэйчүүд Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр аймаг, орон нутгийн төсвөөс 100 сая төгрөг батлагдсан. Төсөл сонгон шалгаруулж 5 иргэнд тус бүр 20,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж шинээр 5 ажлын байрыг нэмэгдүүллээ.	
3.2.2.4	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачлагыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд хамруулах	Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо	148	92	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, ажил хөдөлмөр эрхлээгүй 92 иргэдээс давхардсан тоогоор 146 иргэн ажил эрхэлж, үүнээс 68 иргэн түр ажлын байранд, 33 иргэн төсөл хөтөлбөрт хамрагдан, 45 иргэн байнгын ажлын байранд зуучлагдаж, байнгын ажилтай болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
			Холбогдох арга хэмжээний тоо	2	2	Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлээгүй иргэдийг дараах арга хэмжээнүүдэд хамруулан түр болон байнгын ажлын байртай болгож, Халамжаас-хөдөлмөрт бодлогын хэрэгжилтийг ханган ажилласан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Байнгын сул чөлөөтэй ажлын байрны зуучлалаар 38 иргэн</li> <li>• Жайка олон улсын байгууллагаас хэрэгжиж буй "Ажил турших хөтөлбөр"-т 7 иргэн</li> <li>• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөр төсөлд 5 иргэн</li> <li>• Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 28 иргэн</li> </ul> Нийтийг хамарсан ажил болон түр ажлын байрны зуучлалаар 68 иргэнийг тус тус хамрууллаа.	100

			Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%		ХЭДсангаас 1,3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.	
3.2.2.5	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх	Албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагчдын тоог нэмэгдүүлэх	Ажилд зуучилсан иргэний тооны өсөлт	1192	1195	Хөдөлмөрийн бирж байгуулах хүсэлтийг 2025 оны 4 дүгээр сард Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, хүсэлтийн дагуу Мөнх хэт цахиур төрийн бус байгууллагад биржийн эрхийг 10 дугаар сард олгосон. Үүний дагуу Job center төв байгуулах хүсэлтийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 365 дугаар албан бичгээр хүргүүлж, хариу ирүүлэхийг хүлээж байна. Байнгын ажлын байранд 572, түр ажлын байранд 355, нийт 927 иргэн зуучлагдсан ба 2024 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 22,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дээрх үзүүлэлтийн шалтгаан нь 2025 онд нийтийг хамарсан ажлын төсөв батлагдаагүй, мод тарих арчлах арга хэмжээнд нийт 185 иргэний квот батлагдсан ба өнгөрсөн оноос 231 иргэнээр буюу 55,5%-иар буурсан, төсвийн тодотголоор 7,4 сая төгрөг мод тарих арга хэмжээнд дутуу батлагдсан тул гүйцэтгэлдээ хүрээгүй байна.	50
			Холбогдох арга хэмжээний тоо	1	3	"Нээлттэй Дундговь" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Дундговьчуудын нутгийн золголтын нэгдсэн арга хэмжээний үеэр нээлттэй ажлын байрны өдөрлөгийг зохион байгуулж, сул чөлөөтэй	

						<p>ажлын байруудыг 1000 гаруй иргэнд сурталчилсан.</p> <p>Төрийн албаны Дундговь аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран төрийн албаны ерөнхий шалгалтад хамрагдаж буй иргэдэд сул чөлөөтэй ажлыг байрыг сурталчлах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Жайка олон улсын байгууллагын Ажилд турших хөтөлбөрийг танилцуулах уулзалтыг ажилгүй иргэдэд 3 удаа, Аж ахуй нэгж байгууллагуудад 3 удаа тус тус зохион байгуулахад ажил хайж буй 61 иргэн, Аж ахуй нэгж байгууллагуудын төлөөлөл 75 иргэн оролцож, мэдээлэл авснаар 14 иргэн байнгын ажлын байранд зуучлагдаад байна.</p>	
3.2.2.6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих;	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийх	Хийгдсэн хяналт шалгалтын тоо	1	1	<p>2025 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 68 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна. Үүнээс 6 сумын санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 37 иргэний үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт хийж, үйл ажиллагаатай нь танилцаж, зөвөлгөө мэдээллээр хангаж, ажилласан.</p> <p>2024 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 65 иргэний үйл ажиллагаанд хяналт хийхэд 65 иргэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэд нь 24 байнгын, 42 түр ажлын байрыг бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. 2024-2025 оны хяналт шалгалт хийсэн иргэдийн мэдээлийг бүртгэлжүүлж, мэдээллийн сан үүсгээд байна.</p>	100
			Судалгаа, мэдээллийн тоо	1	1		

			Холбогдох арга хэмжээний тоо	1	1	<ul style="list-style-type: none"> <li>- Сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээр санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар төсөл ирүүлсэн иргэдийн үйл ажиллагаанд анхан шатны хяналтыг хийлгүүлж, хэрэгжих боломжтой төслийг тайлангийн хамт Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт ирүүлж байна.</li> <li>- Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг нь төслийг иргэдээр нэг бүрчлэн хамгаалуулж, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаатай нь танилцах ажлыг гүйцэтгэсэн.</li> </ul> <p>Санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдэд анхан шатны хяналтыг хийж, өөрийн биеэр төслийг танилцуулснаар дэмжигдсэн төслүүд цаашид үр дүнтэй хэрэгжиж байна.</p>	
3.2.2.7	<p>Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Стар ап төслийн шалгаруулалтыг зохион байгуулж иновац шингэсэн шинэлэг санал санаачлагатай ажлын байрны тоо аж ахуй эрхлэгчийг нэмэгдүүлэх</p>	Холбогдох арга хэмжээний тоо	2	2	<p>Шинэ санаа бүхий гарааны бизнес эрхлэх зорилгоор “Старт ап” төслийн шалгаруулалтыг зохион байгуулж, сургалтын арга хэмжээнд 19 иргэн хамрагдаж, үүнээс иновац шингэсэн шинэлэг санал санаачлагатай 2 багийн төсөл шалгарч, 6 байнгын ажлын байрыг бий болголоо.</p> <p>Мөн Говийн бүсийн “Старт ап” арга хэмжээнд оролцсон баг 2-р байранд шалгарч 17,0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.</p>	100
		Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	2	2	Сургалтын арга хэмжээнд 19 иргэн хамрагдаж, 2 багийн 6 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.		
		Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	10.0	10,0	Шалгарсан 1 багийн санхүүжилт 15,0 сая төгрөгийг олгож, 2 шинэ ажлын байр бий болсон.		

			Шинээр бүртгүүлсэн патент /шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо	0	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамаалагч 1 иргэн гар урлалын чиглэлээр шинэ бүтээлийн патентийн эрх авсан байна.	
3.2.2.8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн бүтээгдэхүүнийг сурталчлах	Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо	50	60	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн говийн бүсийн чуулга уулзалтад оролцсон хувиараа хөдөлмөр эрхлэгч 43 иргэн бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж 4.6 сая төгрөг, сумдын зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа болон бусад борлуулалтын цэгээр дамжуулан санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 16 иргэн 20,2 сая, "Намрын өнгө" үзэсгэлэнд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 72 иргэнийг оролцуулж, 20.5 сая төгрөг, мөн Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрт 18 иргэний бүтээгдэхүүнийг нийлүүлэн борлуулж, 14,9 сая төгрөг, нийт санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 149 иргэний борлуулалтыг дэмжиж, ажилласанаар 60,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.	100
			Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	10.8	-	"Намрын өнгө" үзэсгэлэн худалдаанд оролцох хүсэлтэй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт хамрагдсан 72 иргэнтэй хамтран бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг өнгө үзэмжтэй, чанартай байдлаар шинээр шийдэж, 30.7 сая төгрөг зарцуулсан.	
3.2.2.9	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Салбар зөвлөлөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсвийг шийдвэрлүүлэх	Холбогдох арга хэмжээний тоо		1	Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/88 дугаар захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл шинэчлэн батлагдаж, зөвлөлийн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 100 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн.	100

			Төвлөрүүлсэн мөнгөн дүн	60.6	30.0	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй зөрчлийг арилгуулах зорилгоор Хөдөлмөрийн хяналтын Улсын ахлах байцаагчийн актаар 4 байгууллагын 58.0 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна.	
3.2.2.10	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.	ХБИргэн ажиллуулаагүй орон тоо тутамд нөхөн төлбөрийн акт тогтоох	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	800.0	1.4 тэр	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 1,3 тэрбум төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 92,9 хувьтай байна.	100
			Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	20	30	Хөгжлийн бэрхшээлтэй 41 иргэнийг ажлын байранд зуучилж, үүнээс 30 иргэн байнгын, 11 иргэн түр ажлын байранд зуучлагдсан.	
<b>3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар</b>							

	<p>Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөн, хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай төсвийг шийвдэрлүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах</p>	<p>ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх</p>	<p>1</p>	<p>ХАБЭА-н зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулсан цахим нөлөөллийн гурван шторк, таван төрлийн 100 ширхэг гарын авлагыг боловсруулан түгээж, иргэдэд мэдээлэл, зөвлөмжийг хүргэн ажиллалаа.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор ЗДТГ-ын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг нүүрсний олборлолт эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт шалгалт хийж, хэрэгжилтэд үнэлгээ өгсөн.</p> <p>2025 онд улсын хэмжээнд Онцгой байдлын газруудад ХАБЭА-н улсын үзлэгийг зохион байгуулахаар удирдамж, ирүүлсний дагуу аймгийн Онцгой байдлын газрын Хулд сумын эрэн хайх аврах бүлэг, Эрдэнэдалай сумын эрэн хайх аврах салбар, Сайнцагаан сумын гал түймэр унтраах, аврах 25-р анги, улсын нөөцийн 124-р салбар, Сайнцагаан сумын эрэн хайх аврах анги, захиргаа удирдлагын хэсэг гэсэн 6-н хэсэг, салбар, газарт 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 02 дугаар сарын 17-ныг хүртэлх хугацаанд улсын үзлэгийг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Дээр улсын үзлэгийн дүнгээр ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилт 61.5 хувийн биелэлттэй дүгнэгдсэн.</p> <p>Улсын үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулахаар Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагчийн 20 заалттай зөвлөмж хүргүүлж биелэлтийг 89.9 хувьтай хангуулсан үр дүнтэй байна.</p>	<p>100</p>
--	--	--	--	----------	---	------------

			Төлөвлөсөн төсөв		31.8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 11 заалттайгаар баталж гаргасан. Тус төлөвлөгөөнд аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах нийт 31.8 сая төгрөгийн хөрөнгийг тусган, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 55 хувийн биелэлттэй байна.	
3.2.3.2	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;	ХАБЭА зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		7	<ul style="list-style-type: none"> <li>- ХАБЭА-н зөвлөлийн баталсан 2025 оны төлөвлөгөө, хуваарийн дагуу орон нутгийн үйлчилгээний байгууллагуудын ажлын байран дахь эрсдэлүүдийг хяналтын хуудсаар тодорхойлон гаргаж, 32 байгууллагад ХАБЭА-н үзлэг зохион байгууллаа.</li> <li>- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил: Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт” сарын аяны улсын нээлтэд Дундговь аймгийн 15 сумын ХАБЭА-н зөвлөлийн дарга, гишүүд нийт 112 иргэн хамрагдаж, мэдээлэл авсан байна.</li> <li>- Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан ХАБЭА ажилтнуудыг чадавхжуулах цахим сургалтад сумдын ХАБЭА-н зөвлөлийн дарга, гишүүд 105 иргэн хамрагдаж, ХАБЭА-н талаар ойлголт мэдлэгтэй болж, ур чадвараа дээшлүүлсэн.</li> <li>- Бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг эцэг эх, асран хамгаалагчдад түгээх зорилгоор</li> </ul>	77,5

						<p>ойлгомжтой, энгийн хэлээр бичсэн гарын авлага боловсруулж, 100 иргэнд тараасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд зориулан ХАБЭА-н санамж, зааварчилга видео бэлтгэн сайтад байршуулсан.</li> <li>- ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн талаарх сургалтыг 60 гаруй малчдыг хамруулан зохион байгуулсан.</li> </ul> <p>Оффиссын аюулгүй ажиллагааны зөвлөмжийг цахим бичлэг хэлбэрээр гаргаж, иргэдэд түгээж, ажилласан.</p>	
3.2.3.3	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээ шуурхай авах.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг хянан баталгаажуулах арга хэмжээ авах.	Төлөвлөсөн төсөв (сая)	-	-	Аймгийн Засаг даргын 2025.06.03-ны өдрийн А/474 тушаалаар 2,577,800 төгрөгийг батлуулсан.	100
			Тухай бүр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	-	2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 10 үйлдвэрлэлийн осол гарч, 1 ажилтан нас барсан, 6 ажилтан хүнд бэртэлтэй, 3 ажилтан хөнгөн гэмтэл авсан ослуудыг хянан баталгаажуулж, 2 осолд нөхөн төлбөрийн акт тогтоолоо. Шүүхээр осолд өртсөн 1 иргэний нөхөн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлүүлсэн.	
<b>3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар</b>							
3.2.4.1	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжид монгол ажилчдыг ажлуулах	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо(гүйцэтгээр)	-	-	Уул уурхай салбарт ашигт малтмал олборлож, байгаа гадаадын хөрөнгө оруулалттай 8 ААНБ-д 226 гадаад иргэд ажиллаж байна	-
			Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн	-	-		

			орлогын хэмжээ (гүйцэтгэлээр)				
3.2.4.2	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.	Гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	Хяналт шалгалтад хамрагдсан гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын тоо	2	-	Уул уурхай салбарт ашигт малтмал олборлож, байгаа гадаадын хөрөнгө оруулалттай болон туслан гүйцэтгэгчээр гадаад иргэдийг хөдөлмөр эрхлүүлж, байгаа 8 ААНБ-ын 226 гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар ажиллах хүчний түр оршин суух үнэмлэхний хугацаа, хаяг, ажлын байрны төлбөр төлөлт зэрэг асуудлыг хамруулсан. Зөрчил илрээгүй болно. 1 ААНБ-д Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн дагуу ажиллах хүчний квотын зөрүүнд 31,680,000 мянган төгрөгний нөхөн төлбөрийн акт тогтоож, сум орон нутгийн төсөвт 100% төвлөрүүлээ	100

**3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.**

**3.3.1 Нийгмийн даатгалын талаар**

3.3.1.1	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах	Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээг сумдад зохион байгуулж, сайн дурын даатгалын хамралтыг өмнөх оноос нэмэгдүүлнэ.	Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсан иргэдийн тоо	4050	4658	Сайн дурын даатгалд хамрагдсанаар нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж, даатгуулахын ач холбогдлыг тайлбарлаж, сум багийн өдөрлөгт оролцож, сургалт сурталчилгаа хийх, цахимаар хууль тогтоомжийн мэдээллийг хүргэж, ажиллаж байна. Мөн малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50%-ийг төрөөс төлж байгааг малчдад сурталчилснаар 4 улирлаар нийт 4658-ыг хамруулахаас 4056 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулж, төлөвлөгөөг 87.0%-иар биелүүлсэн.	87
3.3.1.2	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх	Тэтгэвэр тогтоолгосон иргэдийн	Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн	6.1	100	2025 оны 11 дүгээр сарын байдлаар Дундговь аймгийн хэмжээнд 8678 тэтгэвэр авагч байгаагаас 2024, 2025 оны шинэ тогтоолт 1158	

	зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	тэтгэврийн цаасан хувийн хэргийг цахимжуулахад шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмжийг худалдан авч цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	хувийн хэргийн эзлэх хувь			иргэний тэтгэвэр буюу нийт тэтгэвэр авагчдын 13,3%-ийг цахимжуулсан байна. 2024 оноос өмнө тогтоогдсон идэвхтэй тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийн хувийн хэргийг сканердах ажлын явц 2025.11.30-ны өдрийн байдлаар 6602 иргэний тэтгэврийн хувийн хэргийг сканердаж файл үүсгээд байна.	89
3.3.1.3	Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх;	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсвийн байгууллагад шат дараалсан арга хэмжээ авч, өр авлага барагдуулах ажлыг зохион байгуулна.	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	70	60	2025 оныг даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах жил болгон зарласантай холбогдуулан авлага бууруулах жилийн төлөвлөгөө гарган ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 14 хоног тутамд НДЕГ-т хүргүүлж, авлага барагдуулах шат дараалсан арга хэмжээг данс хаасан-40, Уулзалт хийсэн -118, Гэрээ байгуулсан-21 ажил олгогчид авч ажилласны үр дүнд 2025 оны эхний үлдэгдэл авлага 70 ажил олгогчийн 606.1 сая төгрөг байснаас 12 сарын 1-ний байдлаар 58 байгууллагын 552.0 сая буюу 91.0%-ийг бүрэн төлж барагдуулсан. Урсгал авлагыг бууруулахаар Итгэлцлийн сарын аяныг зохион байгуулж, 278,1 сая төгрөгийн авлагатай 6 байгууллагатай гэрээ байгуулж, 31,1 сая төгрөгийн авлагыг аяны хугацаанд барагдуулсан бөгөөд мөн 6 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг хаасан байсныг нээж, харилцан итгэл үзүүлж, хамтран ажилласан. 4-р улирлын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 455.7 сая төгрөг байна	100
3.3.1.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн	Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулна.	Эрүүлжсэн иргэдийн хувь	10	25	Эмч мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах, туршлага судлах зорилгоор Баянгол дүүрэг, Орхон, Төв, Өвөрхангай, Өмнөговь аймгуудын эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдтэй 2 удаагийн цахим уулзалт, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулан ажилласан. ҮРДҮН: дээрх арга хэмжээний үр дүнд эмч мэргэжилтний чадавхи сайжран, ХЧА-тай	40

	чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;					иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжин 2025 оны байдлаар 127 иргэнийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. ХЧА-тай иргэдийн тоо өмнөх оноос 10%-иар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдийн эрүүл мэндээ хамгаалах урьдчилан сэргийлэх мэдлэг дутмаг, ахуйн болон зам тээврийн осол нэмэгдэж байгаа зэрэг олон нөхцөл шалтгааны улмаас хүн амын дундах өвчлөл жилээс жилд нэмэгдэж, улмаар тухайн өвчин, гэмтлийн улмаас иргэдийн хөдөлмөрийн чадвар алдах, эдгэрэлт сэргэлт удаашралтай, байгаа нь ХЧА иргэдийн тоог зорилтот түвшинд хүртэл бууруулахад сөрөг нөлөөтэй байна.	
3.3.1.5	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах.	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэдийн судалгааг гаргаж холбогдох тооцоо хийсэн байна.	Гаргасан судалгааны тоо	-	2	Сайн дурын даатгалд 4056 даатгуулагч, Нийт бүртгэлтэй 679 ажил олгогчийн 7285 даатгуулагчийг албан журмын нийгмийн даатгалд хамруулж, 11341 иргэдийн хамрагдалтын судалгааг гарган ажилласан.	100
<b>3.3.2. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана:</b>							
3.3.2.1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах	ГБХНХСайдын баталсан аргачлалын хүрээнд багц үйлчилгээг үзүүлсэн байна.	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлдэг иргэний тоо	-	50	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн багцийн үйлчилгээг үзүүлэхээр "Арвин эрдэнэ" ХХК-тай хамтран ажиллаж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг болон зорилтот бүлгийн 50 өрхийг үйлчилгээнд хамруулан өрх бүрд хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгцээт сургалтуудыг зохион байгуулж, 21 өрхийн 42 иргэнийг бүлгийн төсөлд хамруулан тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.	100
3.3.2.2	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах,	АА бүлэгт архинд донтсон иргэдийг хамруулж нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга	Архинаас гарсан иргэний тоо	0	2	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн архины хамааралтай 2 иргэнийг Жайка ажил турших хөтөлбөрт хамруулж, ганцаарчилсан зөвлөгөө, ажлын байранд дадлагажуулан	100

	архинаас гаргах дэмжих бүлгүүдэй хамтран ажиллах	хэмжээг хэрэгжүүлэх				ажиллуулсанаар Дундговь Ус ОНӨГ-т байнгын ажлын байранд зуучилсан.	
3.3.2.3	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах.	Чадавхжуулах сургалтад хамруулах	Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1	1	Дундговь аймагт зохион байгуулагдсан говийн бүсийн аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын албан хаагчдын уулзалт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн халамжийн үйлчилгээний болон ХБИ-ний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар салбарын албан хаагчдад танилцуулж, харилцан санал солилцлоо.	100
			Сургалтын тоо	1	1	Сумдын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан 16 мэргэжилтнийг 1 удаагийн чадавхжуулах сургалтад хамруулж, албан бичгээр 4 удаа, цахимаар 9 удаа зөвлөмж өгч тэдний мэдлэг ур чадварыг сайжруулсан байна.	
<b>3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар</b>							
3.3.3.1	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах	Төсөв батлуулсан эсэх /Тийм-1, үгүй -2/	1	1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоол, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулган, спортын арга хэмжээ зохион байгуулах зардалд 20 сая төгрөгийг тусгасан.	100
			сургалтын тоо		30	Дундговь аймгийн 6 сумын нийт 734 иргэн, төрийн болон төрийн бус нийт 21 байгууллагын 994 иргэн, асран хамгаалагч нарт 5 удаа нийт 31 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.	
3.3.3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		-	Дундговь аймгийг 2026–2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг олон нийтэд танилцуулах, оролцоонд суурилсан хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд 180 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулан бодлогын танилцуулга, зөвлөлдөх уулзалт, санал авах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулсан байна.	50

3.3.3.3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүй эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшийг бэлтгэх, Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нөхөн үржихүйн чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах	сургалтад хамрагдсан иргэдийн тоо			Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн чиглэлээр сургалт хийх багшийг 2023 онд бэлтгэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн сургалтыг тусгай модулын дагуу явуулдаг бөгөөд уг сургалтанд нийт 65 иргэн хамрагдсан байна.  2025 онд нийт 983 эмэгтэй ЖСА-хэрэглэсэн бөгөөд эм-243, ерөндөг-349, бэлгэвч-184, тариа-275, суулгац-87 хүнийг хамруулсан байна. Нийт хамрагдсан иргэдээс эрсдэлт бүлгийн эмэгтэй 56,5%-ийг эзэлж байгаа бөгөөд үүний 12,5% нь ХБИ хамрагдсан.	100
3.3.3.4	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Дэмжиж төвийг байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх эмчилгээний тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Нэмэгдүүлсэн тоног төхөөрөмжийн тоо	-	1	Усан эмчилгээний тоног төхөөрөмжийг шинээр нэвтрүүлж, тархины саатай, булчингийн чангаралтай 8 хүүхдийг хамруулж, дархлааг дэмжиж, чийрэгжүүллээ. Уг төхөөрөмжийг орон нутгийн сангаас 13,7 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн.	100
3.3.3.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1	2	Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 21 удаа хуралдаж, шинээр тогтоолт 35, сунгалт 159, цуцлалт 1, буцаасан 12, дахин магадлан 101 нийт 308 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн ажилласан. Шинээр тогтоолт – 35 Сунгалт-159 Цуцалт – 1 Буцаалт – 12 Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо - 247	100
3.3.3.6	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой	Арга хэмжээний	-	100	Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон, гамшгийн төрөл тус бүр дээр ажиллах дэд төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй	100

	хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	хэрэгжилтийн хувь		иргэдийн хэрэгцээнд тохируулан засварлан, аймгийн хэмжээнд гамшгийн үед хорогдох байрны тоо 5 байсныг 7 болгон нэмэгдүүлж, бэлэн байдлыг 100 хувь ханган ажиллаж байна.	
3.3.3.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	100

Нийт 6 төрлийн сургалт, 5 арга хэмжээ зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн асран хамгаалагчдад бадминтоны сургалт, Хаягдал цаасаар сагс урлахуй” сургалт, хонхот бөмбөгийн сургалт, саван хийх сургалт, эсгий таавчик урлах сургалт зүү ороох сургалтад нийт 131 иргэн хамрагдаад байна.

Дэлхийн Дауны өдрөөр “Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллах” сэдэвт хэлэлцүүлэг, ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, “Ability expo “цогц арга хэмжээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Тэгш эрх, тэгш оролцоо-2025 цогц арга хэмжээ, Хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдэд байгаль экологи, Монгол ёс заншил, таван хошуу малыг таних, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх, амьдрах ухааны сургалт, явган аялалыг зохион байгууллаа.

Үр дүн: 2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо 50,6 хувьтай байсныг 2025 онд 51 хувьд хүргэсэн.

		<p>Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг нэмэгдүүлсэн арга хэмжээний тоо</p>		<p>“Нийт 5 арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа. Үүнд:  1.Дэлхийн Дауны өдрөөр “Хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллах” сэдэвт хэлэлцүүлгийг Политехник коллеж, ЕБС-ийн 60 багшийг хамруулан зохион байгуулж багш нар ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах арга зүйд суралцсан  2.ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр зохион байгуулсан ажлууд:  -Зуузуугийн найзууд жүжигчилсэн тоглолт  -Дуу, бүжгийн тэмцээн  -Зургийн тэмцээн  -Нарны хүүхдүүд тоглоомын өртөө ажиллуулж нийт 321 хүүхдэд хамрагдсан.  3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд Говийн бүсийн аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Ability expo “цогц арга хэмжээг яам агентлагтай хамтран 450 иргэнийг оролцуулж зохион байгуулсан.  4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Тэгш эрх, тэгш оролцоо-2025 цогц арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд 3 төрөлт тэмцээн, “Иргэдээ сонсоё” “хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 250 иргэн хамрагдсан.  5.Хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдэд байгаль экологи, Монгол ёс заншил, таван хошуу малыг таних, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх чиглэлийн амьдрах ухааны сургалт, явган аялалыг зохион байгууллаа.  Үр дүн: 2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо 50,6 хувьтай байсныг 2025 онд 51 хувь болгож нэмэгдүүлж ажилласан.</p>	
3.3.3.8	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо		2025 онд нийт 41 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгт хамрагдан тогтвор суурьшилтай ажиллаж байна.Үүнд санхүүгийн дэмжлэгт 18, байнгын ажлын байранд 12, түр ажлын байранд 11 иргэнийг тус	100

						тус зуучлан ажиллуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлт 40 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 26 аж ахуйн нэгж, байгууллагын 1,225 ажилтныг хамруулж үзлэг хийхэд ажиллавал зохих 45 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байхаас одоогийн байдлаар 58 хүн ажиллаж байгаа нь шаардлагын биелэлт хангагдсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, аймгийн Нэгдсэн эмнэлэг нийт 226 ажилтантай, ажиллавал зохих 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс 14-ийг ажиллуулж байна. Хамрагдсан 26 ААНБ-аас 21 нь хуульд заасан шаардлагын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүрэн ажиллуулж байна. Мөн Дундговь аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 төрийн бус байгууллага бүртгэлтэй бөгөөд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэгийг үзүүлэн хамтран ажиллаж байна.	
3.3.3.9	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах	Орон нутгийн цахим хуудас, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах	Хүртээмжтэй цахим хуудасны тоо	-	5	Орон нутгийн цахим хуудас болон нийгмийн мэдээллийн хэрэгслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран цаг агаарын мэдээг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дохионы хэлмэрчийн оролцоотойгоор тайлбарлан олон нийтэд долоо хоногт 3 удаа хүргэн, ажиллаж байна. Мөн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас хиймэл оюун ухаан ашиглан мэдээллийн хүртээмжийг сайжруулж, цахим хуудсаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан контентыг тасралтгүй түгээж байна.	100
			Дохионы хэлний сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	10	Дохионы хэлний анхан шатны сургалтыг 17 төрийн байгууллагын 61 албан хаагчдад зохион байгуулаад байна. <input checked="" type="checkbox"/> Луус суманд төрийн байгууллагын 11 алба хаагч	

						<ul style="list-style-type: none"> <li>✓ Сайнцагаан сумын төрийн байгууллагын 42 албан хаагч</li> <li>✓ Эрдэнэдалай сумын төрийн байгууллагын 8 албан хаагч</li> <li>✓ Брайль үсгийн цагаан толгойн анхан шатны сургалтыг харааны бэрхшээлтэй 16 иргэнд зохион байгуулсан.</li> </ul> <p>Үр дүн: Төрийн байгууллагуудын угтах ажилтнуудын дохионы хэлний чадвар сайжирч, сонсголгүй иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>Брайль үсгийн сургалтын үр дүнд төрийн 4 байгууллага хаягаа брайль үсгээр хийж, байршуулсан.</p>	
3.3.3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбар зөвлөл, олон талт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	40	Дундговь аймагт зохион байгуулагдсан говийн бүсийн аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалт 2 удаа зохион байгуулагдаж, 7 гишүүн хамрагдсан. Тус сургалтын хүрээнд комиссын гишүүдэд шаардлагатай хувцас, хэрэглэгдэхүүнээр ханган ажилласан.	30
3.3.3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо	2	3	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нэг цэгийн үйлчилгээний төв болон цахим үйлчилгээний төвийг 1-р давхарт байрлуулан, иргэдэд түргэн	100

		дотор талын хүртээмжийг сайжруулах; /Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв/				шуурхай, хүртээмжтэй үйлчилж байна. Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тус газрын орох, гарах хэсгийг стандартад нийцүүлэн тохижуулж, ариун цэврийн өрөө, дотоод зохион байгуулалтыг ч мөн олон нийтэд хүртээмжтэй байхаар шийдсэн. Мөн үйлчилгээний төвийг зорин ирж буй иргэдийн тав тухыг хангах үүднээс гадна зогсоолыг бүрэн стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээтэй болгож, харагдах байдал, аюулгүй байдлыг сайжруулсан.
						Нийгмийн даатгалын газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам мөн нийтийн бие засах өрөөг засварлаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх бүрэн боломжтой болсон. Иргэдэд үйлчилдэг байцаагч ажилтан нарыг 1 давхарт байрлуулсан. Төрийн 4 байгууллага зөвлөмжийн дагуу налуу зам, авто машины зогсоол, брайль үсгэн хаяг, стандартын ариун цэврийн өрөөг шинээр хийж, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн.

### 3.3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар:

3.3.4.1	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.	Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагааг нийт гэр бүлийн 50 хувьд хүргэнэ.	Хамрагдсан гэр бүлийн хувь	40	50	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйг түгээх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд "Миний гэр бүл-миний толь" аянд 2070 оролцогч, "Ээж хүүгийн болзоо" 60 оролцогч, "Аавын түшиг" 20 оролцогч, "Хүүхэд хайр ирээдүй" дэлхийн хүүхдийг зодож, шийтгэхийн эсрэг дэлхийн өдөрт зориулсан арга хэмжээнд 53 оролцогч, "Ирээдүйгээ ургуульяа" төгөлийн арга хэмжээнд гэр бүлээрээ 386 оролцогч нийт 2589 оролцогчийг тайлант хугацаанд хамрагдуулж ажилласан байна. Нийт гэр бүлийн 17,8%-д хүрч ажилласан байна.	68
---------	--	--	----------------------------	----	----	--	----

			Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо		2	“Хайраа хайрлая, хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлэе” уриан дор зохион байгуулж буй “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд 15 сум, агенлагуудад чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангаж, ажилласан. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны үйл ажиллагааны хүрээнд цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн сэдвээр сургалтыг зохион байгуулсан.	
<b>3.3.5. Ахмад настны талаар:</b>							
3.3.5.1	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах	Ахмад настны тухай хууль, ахмад настны үндэсний чуулганы зөвлөмжийг сурталчилах ажлыг зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан тоо	61	70	Ахмад настны тухай хууль болон холбогдох хуулиуд тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр баталсан тогтоол, журам, тушаал, заавар, аргачлалыг ахмад настанд сурталчлан таниулах ажлыг Тухайн жилд 81 удаа сургалт уулзалт хэлэлцүүлэг давхардсан тоогоор 5828 ахмадад бодлого, шийдвэрийн биелэлтийг сурталчиллаа.	100
			Хамрагдсан хүний тоо	3739	4000	Нийт 5828 ахмад настан хамрагдлаа.	
3.3.5.2	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөвт байгууллага болон ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих	Ахмадын сан байгуулах журмыг ААНБ-дад суртчилах, хэрэгжилтийг хангах	Ахмадын сантай байгууллагын тоо	290	295	Ахмадын сан” байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх аймгийн Ахмадын хорооноос 15 сумдын Ахмадын хорооны дарга нартай байгуулсан гэрээнд тодорхой заалт тусган хэрэгжилтийг хангуулахаар ажилласан. Аймгийн хэмжээнд “Ахмадын сан”-тай 309 байгууллагатай болж, сангаасаа хаврын тэргүүн сарын шинийн нэгэн ОУ-н ахмадын баярын угтаж, 335 байгууллага, ААН 7656 ахмадад 529,2 сая төгрөгний хүндэтгэл үзүүллээ. Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөтэй 83 байгууллагад 179 хүн хамрагдаж байна.	100
			Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөртэй аж ахуйн нэгж байгууллагын тоо	86	70		
3.3.5.3				11920			100

	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах	Ахмадын ордон, өргөөнд зохион байгуулагдсан үйл ажиллагааны хүртээмж, оролцоо нэмэгдсэн байна.	Үйлчилгээнд хамрагдсан ахмад тоо		9000	2025 онд өргөө танхимаар 384 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 18081 ахмад хамрагдлаа	
3.3.5.4	Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих	Ахмад настануудын нас бие бялдрынх нь онцлогт тохирсон алхалт, дасгал хөдөлгөөнд хамруулах	Хамрагдсан хүний тоо	1947	2700	Алхалтад 2571, 23 ахмад унадаг дугуйгаар тогтмол хичээллэж, цэнгээнт бүжгийн сургалтад 125, нийт-2787 ахмад настан хамрагдсан байна.	100
			Үзүүлсэн үйлчилгээний төрөл	-	-	Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу ахмад настны идэвхитэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ, гэрээр асрах үйлчилгээг гүйцэтгүүлэхээр Монголын Улаанзагалмай нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 4 сумын 197 ахмадыг хамруулан, цогц үнэлгээг хийж, тулгамдсан асуудлыг эрэмбэлэн тогтоож, хэрэгцээнд суурилсан цогц тусламж үйлчилгээг үзүүллээ. Мөн гэрээр асрах үйлчилгээнд Сайнцагаан сумын гэрээс гарах боломжгүй нийгмийн амьдралаас тусгаарлагдсан 25 ахмадыг хамруулан нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгцээнд суурилсан цогц үйлчилгээг үзүүллээ.	
3.3.5.5	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах	Ахмад настны цогц үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	-	Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу ахмад настны идэвхитэй насжилтыг дэмжих цогц үйлчилгээ, гэрээр асрах үйлчилгээнд хамрагдах ахмад настануудад журмын дагуу цогц үнэлгээг хийх ажлыг зохион байгууллаа. Үүнд:	100

						<ul style="list-style-type: none"> <li>Идэвхитэй насжилтийн үйлчилгээнд хамрагдсан 175 ахмад настанд</li> <li>Гэрээс асрах явуулын үйлчилгээнд хамрагдах 25 ахмад настанд үнэлгээ хийж, үйлчилгээнд хамруулсан.</li> <li>10 дугаар сарыг “Идэвхитэй насжилт” уриан дар сарын аяныг зохион байгуулж, тус аяны хүрээнд Өндөршил, Говь-Угтаал, Цагаандэлгэр суманд ахмад настны цогц үнэлгээ хийхэд зөвлөн туслах баг ажиллалаа.</li> </ul>	
3.3.5.6	Ахмад настны цогц үнэлгээ хийж, цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	Цогц тусламж үйлчилгээг үзүүлэх	Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх	-	1	Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд уялдуулан зохицуулах орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг Аймгийн Засаг даргын 2025.04.30-ны өдрийн А/344 тоот захирамжаар байгуулаад байна.	100
			Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	-	-	Ахмад настны цогц үнэлгээг хийх ажлыг Эрүүл мэндийн газар, Ахмадын хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулж, 15 сумын холбогдох мэргэжилтэнтүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж, тайланг эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн.	
3.3.5.7	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, ахмад настны мэргэшлийн ур чадварыг үнэлэх, мэргэшил ур чадварыг залууст эзэмшүүлэх	Хөтөлбөрт хамрагдсан ахмадын тоо	32	15	Ахмадын зөвлөх үйлчилгээнд 30 аж ахуйн нэгж, байгууллагын төсөл шалгарч, төслөө бүрэн хэрэгжүүлсэн 28 ахмадад 30.2 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.	100
			Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо	46	50	2025 онд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газартай хамтран өөрийн өргөн мэдлэг, мэргэжлийн өндөр ур чадвар, үнэтэй туршлага, шилдэг арга барилаа залуу хойч үедээ өвлүүлэн эзэмшүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж буй 6 ахмадыг “Гэрийн сайн багш”-аар шалгарууллаа. Ингэснээр аймгийн хэмжээнд нийт “Гэрийн сайн багш”-ийн тоо 52-д хүрээд байна.	

	оролцуулах, урамшуулах;		Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо		2	Нийгмийн даатгал, Орон нутгийн өмчийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, татварын хяналт шалгалтын хэлтэс зэрэг байгууллагуудын ахмадууд ажлаж байсан байгууллагууддаа Ахмадаасаа суралцъя уулзалт зохион байгуулж, төрийн албаны үнэ цэнэ, үнэт зүйл, эрхэм чанар, онцлогийн талаар яриулж, үнэтэй зөвлөгөө зөвлөмж өгсөн. Мөн сум, байгууллага бүр "Ахмадаасаа суралцъя", "Ахмад ажилтны зөвлөх үйлчилгээ", төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтнаа алдаршуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Ахмад ажилтны зөвлөх үйлчилгээ арга хэмжээний хүрээнд 28 уулзалт арга хэмжээнд 399 албан хаагч, "Ахмадаасаа суралцъя" арга хэмжээний хүрээнд 60 удаагийн уулзалт арга хэмжээг зохион байгуулж, 399 төрийн албан хаагч хамрагдсан байна.	
3.3.5.8	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг иргэдийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Журам баталсан эсэх			Засгийн газрын 2024.12.25-ны 243 дугаар тогтоолоор батлагдсан Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023.12.04-ний 8 дугаар тогтоолоор батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд дэмжлэг хөнгөлөлт олгох журмаар тус тус шийдвэрлэж байна.	100
			Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	100	100	Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 5 өрхөд нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 10,0 сая төгрөгийн оршуулгын мөнгөн тэтгэмжийг олгосон.	
3.3.5.9	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын	50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргах	50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэг байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо үүнээс	-	1	Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас дээш ажилтантай 2 ААНБ-д хяналт шалгалт хийхэд нийт ажилтныхаа 2 хувьд ахмад настан ажиллуулж, зөрчил илрээгүй байна.	100

	доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна." гэсэн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, хяналт тавих		ажиллаж байгаа ахмадын тоо				
3.3.5.10	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах	Тухайн жилийн ногдох орлогоос 1 хүртлэх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо		5	Жилийн эцсийн тайлан гарснаас хойш тоо баримт гарах тул үнэлэх боломжгүй.	-
<b>Хэрэгжилтийн дундаж</b>							<b>91,1</b>

БАТАЛГААЖУУЛСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



С.МӨНХЧУЛУУН

ХЯНАСАН:  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

НЭГТГЭСЭН:  
НБХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Т.ТҮМЭНЦЭЦЭГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН



Г.МАНДУХАЙ